



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 1345

Чойбалсан

Г

Комисс томилох тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх "Дайчилгааны 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн суралтын материаллаг баазыг нэмэгдүүлэхэд шаардлагатай бараа материал" ажлыг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Энхбилэг

-Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штафын тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа

Нарийн бичгийн дарга:

Б.Адъяа

-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

Гишүүд:

М.Гансүмбэр

-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Э.Отгонцэцэг

-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн нууцын дарга, архивын хэрэг хөтлөгч

Л.Бат-Эрдэнэ

-Гүйцэтгэгч компанийн төлөөлөл "Гантэлмэн" ХХК-ийн менежер

2.Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх "Дайчилгааны 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн суралтын материаллаг баазыг нэмэгдүүлэхэд шаардлагатай бараа материал" ажлыг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулж, дүгнэлтийг баталгаажуулах ажлыг зохион байгуулахыг комиссын дарга (Ц.Энхбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЁЛ